

БАТЛАВ.

ДАШИНЧИЛЭН СУМЫН ЗАСАГ

ДАРГА  Д.ЛУТТӨМӨР

2016 ОНЫ НИЙГМИЙН ХАРИУЦЛАГЫН ГЭРЭЭ

2016.06.21

Монгол улсын хүчин төгөлдөр мөрдөгдөж байгаа холбогдох хууль, тогтоомжуудыг хэрэгжүүлэх үүднээс нэг талаас орон нутгийн төрийн захиргааны байгууллагыг төлөөлж *ЗДТБ-ын дарга* /Албан тушаал/ *М. Болорсүхэр* /нэр/ нөгөө талаас *Бэрэмшэн нурцан* ХХК төлөөлж *Тохирал* /албан тушаал/ *Д. Ганбат* /нэр/ нар дараах нөхцлийг тохиролцож энэхүү гэрээг байгуулав.

Нэг. Гэрээний нөхцөл

- 1.1 Энэхүү гэрээ нь орон нутагт уул уурхайн үйлдвэрлэл эрхэлж байгаа хувийн хэвшил, гандны хөрөнгө оруулагч компани, байгууллагуудын үйл ажиллагааг хуульд нийцүүлэн явуулах, хайгуул олборлолтонд байгаль орчинд ээлтэй технологийг ашиглах, нөхөн сэргээлтийг холбогдох стандартын дагуу хийн хүлээлгэж өгөх, орон нутгийн иргэдийг ажлын байраар хангах, сум орон нутгийн хөгжилд чиглэгдсэн үйл ажиллагааны зохион байгуулалтанд оролцох, төрийн байгууллага иргэд, хувийн хэвшлийн харилцан хамтын ажллагааг зохицуулахад гэрээний нөхцөл оршино.
- 1.2 Энэхүү гэрээ нь 2016 он 12 сарын 31-ийг хүртэл хүчин төгөлдөр байх бөгөөд дараа жилийн 1 сард гэрээний хэрэгжилтийг дүгнэн хоёр талын хүсэлтээр дахин сунгалт хийж болно.

Хоёр. Төрийн захиргааны байгууллагын хүлээх эрх үүрэг

- 2.1 байгаль орчинд ээлтэй технологи нэвтрүүлэх үйл ажиллагааг дэмжин мэргэжэл арга зүйн туслалцаа үзүүлнэ.
- 2.2 үйлдвэрлэл үйл ажиллагаа явуулах орчин нөхцлөө сайжруулж, тохижуулах ногоон байгууламж бий болгох зэрэг үйл ажиллагааг дэмжин, туршлагыг олон нийтэд түгээн сурталчилах.
- 2.3 Улс аймаг орон нутгийн төсөвт оруулах татвар хураамж төлөлт, сум орон нутгийн хөгжилд оруулсан хувь нэмрийг үнэлж шагнаж урамшуулах, улс аймгийн шагналд тодорхойлох.
- 2.4 сум орон нутгийн ажилгүй иргэдийн дундаас шаардлагатай мэргэжлийн боловсон хүчин, ажлын чадвартай ажилдчаар хангах ажлыг зохион байгуулах.
- 2.5 Байгаль орчныг хамгаалах тухай хууль, Ашигт малтмалын тухай хууль, болон бусад БО-ны чиглэлийн хууль тогтоомжуудын хэрэгжилтийг хангаж ажиллана.

Гурав. Уул уурхайн үйлдвэрлэл эрхлэгчийн хүлээх үүрэг

- 3.1 Байгаль орчныг хамгаалах тухай хууль, Ашигт малтмалын тухай хууль, болон БО-ны чиглэлийн хууль тогтоомжуудыг хэрэгжүүлэн ажиллах.
- 3.2 Байгаль орчинд ээлтэй технологийг нэвтрүүлэн нутгийн ард иргэд малчдын бүртгэлтэй хамтран тэдний санал бодлыг хүндэтгэн үйл ажиллагаандаа тусган хэрэгжүүлнэ.
- 3.3 Санхүүгийн тайлан тэнцлээ хуулийн дагуу үнэн зөв гаргаж, татвар хураамжаа хугацаанд төлж байна.
- 3.4 сум орон нутгийн иргэдийг ажлын байраар хангах, ажилгүйдэл ядуурлыг бууруулах бодлогыг дэмжин ажиллана.
- 3.5 Захиргааны болон статистик мэдээ судалгааг хугацаанд хууль тогтоомжид заасны дагуу үнэн зөв гаргаж өгнө.
- 3.6 ажиллах орчин нөхцлөө сайжруулж тохижуулна.
- 3.7 Онцгой нөхцөл байдал үүссэн нөхцөлд техник, хүн хүчний болон мэргэжил арга зүйн туслалцаа дэмжлэг үзүүлнэ.
- 3.8 сум орон нутгаас зохиогдох урлаг, соёл, уралдаан тэмцээн, баяр ёслолын болон байгаль хамгаалах, хүмүүнлэгийн үйл ажиллагаанд идэвхитэй оролцоно.
- 3.9 нийтийн албанд нийтийн болон хувийн ашиг сонирхлыг зохицуулах, ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай хуулийн 17 -2 дахь заалтанд заагдсан албан тушаалтны ашиг сонирхлын зөрчилд оруулахгүй үйл ажиллагааны зохион байгуулалтын чиглэлээр хандив дэмжлэгийг үзүүлнэ.

Дөрөв. Нийгмийн хариуцлагын гэрээний хүрээнд

хийгдэх ажлууд

- 4.1. Орон нутгийн малчдын амжиргаанд дэмжлэг үзүүлж мал, мах, цагаан идээг зах зээлийн үнээр худалдан авах
- 4.2 Эрх ашиг нь хөндөгдөж байгаа малчдын нийгмийн асуудлыг шийдэх, нөхөн олговор олгох

4.3 Орон нутагт ажлын байр нэмэгдүүлж, нутгийн иргэдийг ажлын байраар хангах, туршлагжуулах ажлыг зохион байгуулах

4.4 Хараат багийн төвд ширээ сандал авах, хүний эмчийн байр барих

4.5 Сумын төвийн ЕБС-ийн орчинг тохижуулна.

4.6 Сум орон нутгаас зохиогдох урлаг соёл, уралдаан тэмцээн, баяр ёслолын болон байгаль хамгаалах, хүмүүнлэгийн үйл ажиллагаанд оролцох.

4.7 Сумын төвийн нэгдсэн хогийн цэг орчмын хог хаягдлыг түрж, гарцууд гаргах

4.8 Ахмадын байр засварлах

4.9 Бүрэн дунд сургуулийн дээврийн төмөр авчирч өгөх

Тав. Гэрээний хариуцлага

5.1 Гэрээний заалтуудыг хэрэгжүүлэх чиглэлээр талууд өөрслөөсөө шалтгаалах бүхий л арга хэмжээг авч хэрэгжүүлсэн байна.

5.2 гэрээний хэрэгжилтийг 2 тал хамтран дүгнэнэ

5.3 гэрээгээр хүлээсэн үүргээ хангалтгүй биелүүлсэн тохиолдолд цаашид төрийн захиргааны байгууллагаас үзүүлэх дэмжлэгийг зогсоож, гэрээг дахин сунгахгүй.

5.4 гэрээний хариуцлагыг 2 тал харилцан хуулийн дагуу хүлээх ба гэрээнд шууд заагдаагүй асуудлыг Монгол улсын хүчин төгөлдөр мөрдөгдөж байгаа хууль, тогтоомжуудын дагуу шийдвэрлэнэ.

5.5 Энэ гэрээний биелэлттэй холбогдсон маргаантай асуудлыг зөвшилцөн шийдвэрлэх бөгөөд харилцан зөвшилцөлд хүрээгүй тохиолдолд шүүхээр шийдэрлүүлж болно.


Зургаа. Бусад зүйл

6.1 талууд гарын үсэг зурснаар гэрээ хүчин төгөлдөр болно.

Гэрээ байгуулсан:

Захиргааны байгууллагыг төлөөлж

ЗДТГ-ын даргын үүрэг гүйцэтгэгч албан тушаалтай Ц.Болорцэцэг



"Бэрхийн нурамт" ХХК-г төлөөлж

Захирал албан тушаалтай

..... А.Ганбат

Handwritten signature of A. Ganbat in black ink, written over a faint rectangular stamp.